


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлд:

“ХХИХ.4. “Хүчээ нэгтгэе” уриан доор “Төр, хувийн хэвшлийн хаврын хэлэлцүүлэг” нэртэйгээр “Монголын эдийн засгийн чуулган” арга хэмжээний I үе шатыг 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулах гэж байгаа талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан Эдийн засгийн чуулганы нэгдсэн болон салбар хуралдаан дээр Засгийн газраас баримтлах бодлого, салбарын хууль тогтоомж, хөгжлийн хөтөлбөрийг УИХ-д өргөн мэдүүлэхийн өмнө хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэдээр хэлэлцүүлэн сурталчлах, олон нийтийн санал, зөвлөмжийг авч тусгахаар төлөвлөж байгаатай холбогдуулан тус арга хэмжээнд оролцох бэлтгэлийг ханган хариуцлагатай хандаж, салбарынхаа бодлого, хөтөлбөрийг нийтэд өргөнөөр сурталчлахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР